

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 04 ДҮГЭЭР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**


2024 оны 05 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 04 дүгээр сарын биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын 36 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Нийт арга хэмжээний 94.4 хувь нь үр дүнтэй буюу 100 хувь, 2.8 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувь, 2.8 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувьтай үнэлэгдсэн байна. (График 1, Хүснэгт 1)

График 1



Хүснэгт 1

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Хувь
	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	Дундаж хувь
		100%	90%	70%	50%		
1	2	3	4	5	6	7	8
36	34	-	1	1	-	-	97.8

Зорилт тус бүрээр ангилан авч үзвэл Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” болон Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна” арга хэмжээнд тусгагдсан ажлууд тус бүр 100 хувь, “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” арга хэмжээнд тусгагдсан ажлууд 98.1, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд

“Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ” арга хэмжээнд тусгагдсан ажлууд 85 хувиар үнэлэгдсэн. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	0-30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Технологийн дэвшилд тулгуурлан иргэний хяналтыг сайжруулна	1	1	-	-	-	-	100
2	Гадаадын холбогдох зөвшөөрөл, мэдээлэл, эрхлэн зохион байгуулна	7	7	-	-	-	-	100
3	Олон талт ажиллагааг чадварлаг хүний бүрдүүлж, чадварыг бэхжүүлнэ	26	25	-	-	1	-	98.1
4	Инновацад цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ	2	1	-	1	-	-	85
Нийт		36	34	-	1	1	-	97.8

Чиглэл тус бүрээр авч үзвэл Виз, зөвшөөрлийн газар, Иргэний харьяаллын газар, Зөрчил шалган шийдвэрлэх газар, Санхүүгийн хэлтэс, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс, Хангалт, үйлчилгээний хэлтсүүдийн хэрэгжүүлсэн арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 100 хувиар үнэлэгдсэн. Харин үнэлгээ буурсан арга хэмжээнд:

- Захиргаа, удирдлагын газар: Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн-1,
- Мэдээллийн технологийн хэлтэс: Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан 1 (Хүснэгт 3)

Хүснэгт 3

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	0%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Захиргаа, удирдлагын газар	15	14	-	-	1	-	96.9
2	Виз, зөвшөөрлийн газар	3	3	-	-	-	-	100
3	Иргэний харьяаллын газар	1	1	-	-	-	-	100
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	3	-	-	-	-	100

1	2	3	4	5	6	7	8	9
5	Санхүүгийн хэлтэс	3	3	-	-	-	-	100
6	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс	4	4	-	-	-	-	100
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	1	1	-	-	-	-	100
8	Мэдээллийн технологийн хэлтэс	3	2	-	1	-	-	90
9	Хангалт, үйлчилгээний хэлтэс	1	1	-	-	-	-	100
10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
11	Санхүүгийн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
Нийт		36	34	-	1	1	-	97.8

Мөн газар, хэлтсүүдийн буюу Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1, Санхүүгийн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1, нийт 2 арга хэмжээ 100 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2024 оны 04 дүгээр сард төлөвлөн гүйцэтгэсэн 36 арга хэмжээний хэрэгжилт 97.8 хувьтай үнэлэгдлээ. Цаашид дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай. Үүнд:

1. “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувьтай үнэлэгдсэн “Байгууллагын архивын 2023 оны баримтад данс, бүртгэл үйлдэх” арга хэмжээ (26):

- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу зохион байгуулалтын нэгжүүдээс архивд хүлээн авсан баримтыг байнга ба түр хадгалах хугацаагаар нь ангилан бүртгэл үйлдэх;

2. “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувьтай үнэлэгдсэн “ISM систем дэх хуучин бүртгэлийг харах программ хангамжийг хөгжүүлэх” арга хэмжээ (36):

- Гадаадын иргэний бүртгэл, хяналтын систем (ISM) ашиглалтаас гарсантай холбогдуулан хуучин бүртгэлийн түүхийг харах программ хангамжийг хөгжүүлэн 04 дугаар 23-ны өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлж, холбогдох албан хаагчдад хандах эрхийг нээж өгчээ.

3. “Үр дүнтэй” буюу 100 хувьтай үнэлэгдсэн 34 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.